- Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг цахим системээр батлуулах, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эрх шилжүүлэх, төлөвлөгөө батлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх;

гэж тодорхойлсон байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол хэлний тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- ЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугээр тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай";
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт орсон;
- Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг;
- Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг;
- Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг;
- Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг;
- Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг;
- Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг;
- Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам;
- Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам;
- Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам;

Тус байгууллагад дотоод аудитын алба байхгүй бөгөөд тайлант онд Нийслэлийн дотоод аудитын газраас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүгийн чиг үүргийг нягтлан бодогч болон төсвийн шууд захирагч хэрэгжүүлдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2019 оны А/153 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2020 оноос мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,711.2 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн *байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 489.6 | 882.8 | 393.2 |
| Урьдчилгаа | 3,000.0 | - | (3,000.0) |
| Бараа материал | 66,921.1 | 57,888.0 | (9,033.2) |
| Үндсэн хөрөнгө | 334,827.1 | 405,178.3 | 70,351.2 |
| **Нийт хөрөнгө** | **405,237.9** | **463,949.1** | **58,711.2** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 405,237.9 | 463,949.1 | 58,711.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **405,237.9** | **463,949.1** | **58,711.2** |

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны өөрчлөлт нь албан хаагчийн цалингийн зөрүүг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансанд тавилга хийлгэхээр өмнөх онд төлсөн 3,000.0 мянган төгрөгийн төлбөрийг бүртгэсэн байсныг тайланд онд тавилгыг хүлээн авч, данс бүртгэлд тусган, урьдчилгаа дансыг хаасан байна.

Бараа материал дансны үлдэгдлийн өөрчлөлтөд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах 40,612.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 46,976.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,542.7 мянган төгрөгийн хангамжийн материалыг акталж устгасантай холбоотой. Бараа материалын үлдэгдэл нөөцийн 72.6 хувийг ажилтан албан хаагчдад ашиглуулж байгаа хангамжийн материал болон үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүд үлдсэн хувийг бичгийн цаас, принтерийн хор, албан ажлын маягт болон аж ахуйн материалын 1 сарын хэрэглээний үлдэгдэл нөөц эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 405,178.3 мянган төгрөг болсон нь НЗДТГ болон НАТХБХТ-өөс үнэ төлбөргүйгээр шилжин ирсэн 159,526.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 13,171.5 мянган төгрөг, Нийслэлийн мэдээ тайлангийн нэгдсэн системийн сайжруулалт хийсэн 17,000.0 мянган төгрөгийн программ хангамжаар тус тус нэмэгдэж, НӨХГ-ын даргын 6 удаагийн тушаал шийдвэрүүдийг үндэслэн НАТХБХТ болон НТУГ ОНӨТҮГ-т шилжүүлсэн 50,659.9 мянган төгрөг, данс бүртгэлээс хасаж, акталсан 29,948.5 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 463,949.1 мянган төгрөг болж, 58,711.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 2,151,187.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 22,500.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,173,687.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг төслийн саналыг дээд шатны байгууллага нь 2,173,687.5 мянган төгрөгөөр хэвээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,935,172.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 57,370.0 мянган төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй гарч, байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 1,957,672.2 мянган төгрөгийг зарцуулж, 34,870.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,957,672.2 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 166,277.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,203.4 мянган төгрөг, хангамж, бараа материал, урсгал засвартай холбоотой зардлыг 3,499.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,468.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **70418-Худалдан авах ажиллагаа хөтөлбөр** | **2,173,687.5** | **1,957,672.2** | **216,015.3** | **90.1** |
| 1-1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,956,187.1 | 1,781,738.6 | 174,448.5 | 91.1 |
| 1-2 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 217,500.4 | 175,933.6 | 41,566.8 | 80.9 |
| | **ДҮН** | **2,173,687.5** | **1,957,672.2** | **216,015.3** | **90.1** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар:

- НЗД-ын А/33 дугаар захирамжаар НАОБТГ-аас 1,400.0 мянган төгрөг;
- НЗД-ын А/294 дүгээр захирамжаар ажилтан, албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор 450,000.0 мянган төгрөг;
- НЗД-ын А/391 дүгээр захирамжаар ОУ-ын жишиг гэрээний сургалтад 20,000.0 мянган төгрөг; нийт 471,400.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

Зарцуулалт нь дэлгэрэнгүйгээр харуулбал:

- Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газраас ажилласан ажилтнуудад хуваарилсан зардалд 1,400.0 мянган төгрөгийг;
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус бүр 15.0-40.0 сая төгрөгийг 18 ажилтанд 450,000.0 мянган төгрөгийг;
- Нийслэл хотод хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрийг амжилттай зохион байгуулах, гэрээний харилцааг олон улсын түвшинд хүргэх зорилгоор 10 албан хаагчийн сургалтын төлбөр 20,000.0 мянган төгрөг; нийт 471,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

*/мянган төгрөгөөр/*

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэг-жилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Худалдан авах ажиллагаа | 2025.01.01 2025.12.31 | Хөтөлбөрийн хүрээнд;<br>- Үндсэн үйл ажиллагааг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх<br>- Ажил олгогчоос тэтгэмж, урамшуулал олгох; | 90.1 хувь | 2,173,687.5 | 1,957,672.2 |

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 70,783.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу төсөвт өртөгтэй нь харьцуулан 60 аж ахуйн нэгж, байгууллагаас 50,783.6 мянган төгрөг, 1 иргэнтэй 20,000. мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн өмч хөрөнгө, засвар үйлчилгээний зардлыг гаргахдаа төрийн хэмнэлт, үр ашиг, төсвийн сахилга батыг нэн тэргүүнд харгалзан үрэлгэн зардал гаргахгүй байх, өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийн ажлын үр дүнгээр урамшууллыг олгох, нягтлан бодогч, нярвын хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хяналт, хадгалалттай холбоотой ажил үүргийн давхардлыг өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийн ажлын чиг үүрэгтэй давхцуулахгүй байх, БҮТЭЗ гэж бүртгэж байгаа үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг стандартын дагуу үнэн зөв бүртгэх, аж ахуйн болон хүнс, барилгын засварын материалыг бусад хангамжийн материалаас салгаж бараа материалыг ангиллын дагуу бүртгэх,

байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажилтнуудад олгодог орон сууцны дэмжлэг үзүүлэх тэтгэмжийн мөнгөн дүнг тодорхой болгох, тэтгэмжийг хавтгайруулан олгохгүй байх, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх, актлах арга хэмжээг авах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Н.Бадамхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн тайланг, суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,553,712.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,305.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг бууруулах арга хэмжээ авч ажилласнаар цалин, хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-тэй холбоотой зардлыг 166,277.6 мянган төгрөгөөр, шуудан холбоо, интернэтийн зардал 5,474.8 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардлыг 1,203.4 мянган төгрөгөөр, тус тус хэмнэлтийг бий болгожээ. Тухайлбал,

- Батлагдсан орон тоо 40 байхаас 36 албан хаагч ажилласнаас цалин болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэн;
- Нийтлэг үйлчилгээний газартай түрээсийн гэрээг шинэчлээгүй тул түрээсийн зардал хэмнэгдсэн;
- Цахим системд нэвтэрсэнтэй холбоотой Нийслэлийн ХААА-уудын тайланг тайлангийн нэгдсэн системд нэгтгэснээр шуудангийн үйлчилгээний зардал хэмнэгдсэн;

**Судалгааны үр дүн, нөхцөл байдал**
Ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны үр дүн дараах байдалтай байна.
Үүнд:

- Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр олгох тухай ЗГ-ын 6 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 88 дугаар тогтоолын дагуу нэг албан хаагчид ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлт 34.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөгийг тус тус олгож байна. Албан хаагчдын унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 261,310.0 мянган төгрөг;
- Батлагдсан төсөвт гадаад томилолт, хурал зөвлөгөө арга хэмжээнд зарцуулах зардал төсөвлөөгүй байна;

- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна;
- Тус байгууллагын данс бүртгэлд дараах программ хангамж бүртгэлтэй байна. Үүнд:
  - ✓ Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программыг 2013 оноос хойшнягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд ашигладаг бөгөөд тайлант оны данс бүртгэлд тусгагдсан дүн нь 990.0 мянган төгрөг;
  - ✓ Нийслэлийн мэдээ тайлангийн программыг 2019 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд тайланд онд нэмэлт хөгжүүлэлт 17,000.0 мянган төгрөгөөр хийсэн, данс бүртгэлд тусгагдсан дүн нь 36,900.0 мянган төгрөг;
- Сургалт, семинар, хурал зөвлөгөөн зохион байгуулагдаагүй бөгөөд төсөвт зардал гараагүй байна ;
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаагүй байна;
- Худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 тушаалаар 39 албан хаагч ажиллахаас тайланд онд 36 орон тоогоор ажилласан байна. Тус байгууллагад орон тооны цомхотгол хийгдээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,215,582.2 мянган төгрөгийн гүйлгээг, зарлагын 1,264,483.5 мянган төгрөгийн гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. 2024 оны 8 сард орсон Нийслэлийн агентлагуудын шинэ байрны 296 м.кв талбай */дарга, бичиг хэрэг, мэдээллийн технологийн хэлтсийн өрөө болон цайны өрөө/* засвар хийж, төсвөөс 146,525.1 мянган төгрөгийн засварын зардал гаргасан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д *"зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, туушттай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах"*; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 4.2.7.*"аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх"*; гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмч хөрөнгө, засвар үйлчилгээний зардлыг гаргахдаа төрийн хэмнэлт, үр ашиг, төсвийн сахилга батыг нэн тэргүүнд харгалзан үрэлгэн зардал гаргахгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Нийт албан хаагчдын 67 хувьд нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор НЗД-ын захирамж, ТШЗ-ийн тушаалаар нийт 543,600.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг мөнгөн дүнг ялгавартайгаар, дийлэнхэд хавтгайруулан олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6. "*үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх*"; 4.2.1-д *"зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, туушттай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах"*; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажилтнуудад олгодог орон сууцны дэмжлэг үзүүлэх шалгуур, тэтгэмжийн мөнгөн дүнг тодорхой болгох, тэтгэмжийг хавтгайруулан олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Өмнөх оны аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын аудитаар 19,863.2 мянган төгрөгийн 3 зөрчил, нийцлийн аудитаар 1 зөрчил тус тус илэрч, алдаа зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснийг, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 19,863.2 | 3 | 19,863.2 | 100.0 |
| Нийт дүн | 4 | 19,863.2 | 4 | 19,863.2 | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараагийн аудитаар анхаарах дараах асуудал байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт "*Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ*"-нд 31-60 насны Монгол улсын иргэдэд зориулсан 190.0-200.0 мянган төгрөгийн багцын үнэ тооцон 3Г-аас жил бүр гаргаж байгаа төсвийн зардалтай давхцан, албан хаагчдаа эрүүл мэндийн шинжилгээнд оруулж, 16,806.0 мянган төгрөгийн зардал гаргасан;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110,704.8 мянган төгрөгийн 2 алдаа [1] илэрснээс аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Батлагдсан төсөв, гүйцэтгэл нь төсвийн хэлбэлзлийн тайлангаас 15,205.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "толилуулга" батламж мэдэгдлүүдийг;
- Хагас жил болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тооллогын комиссын тоолсон хөрөнгийн тоо ширхэг нь эд хариуцагчийн картаар бүртгэлтэй хөрөнгөөс 95,499.3 мянган төгрөгийн илүү байгаа нь санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг;

Аудитаар нийт 22,198.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 22,198.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,107.1 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөхийг санал болгосон.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

<u>Илрүүлэлт-1</u>: Өмч хамгаалах байнгын зөвлөлийн */өөрийн үндсэн чиг үүргийн ажлаа хийж буй нягтлан бодогч, нярав орсон/* гишүүдийн ажлын байрны чиг үүргийн давхардал болон ажлын үр дүнг үнэлж дүгнэлгүйгээр жилд 2 удаа нийт 10,018.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь *УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл*

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Ямар нэгэн нөлөөнд автаагүй байх,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4."*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*", ТӨБЗГ-ын 2018 оны 89 дүгээр тогтоолын хавсралт "Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам'-ын 4.2 "*Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийн ажлын үр дүнгээс хамааруулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулал олгоно.*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*эрх ба үүрэг*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийн ажлын үр дүнгээр урамшууллыг олгох, нягтлан бодогч, нярвын хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хяналт, хадгалалттай холбоотой ажил үүргийн давхардлыг өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийн ажлын чиг үүрэгтэй давхцуулахгүй байх;

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

*__Илрүүлэлт-1__*: Бараа материалыг ангиллын дагуу бүртгээгүй, аж ахуйн материалын дансанд хүнс, бэлэн бүтээгдэхүүн, засварын ажлын 6,418.1 мянган төгрөгийн материалуудыг бусад хангамжийн материалын дансанд бүртгэж, гүйлгээ хийсэн байна.

Энэ нь УСНББОУС-12 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*", 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*үнэлгээ ба хуваарилалт*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Аж ахуйн болон хүнс, барилгын засварын материалыг бусад хангамжийн материалаас салгаж бараа материалыг ангиллын дагуу бүртгэж, гүйлгээ хийх;

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*__Илрүүлэлт-1__*: Үндсэн хөрөнгийн шинжтэй 5,762.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 *Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3. жинхэнэ хэрэгжилтийн ; 5.1.4. үнэн зөв байх ; Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам 10 дугаар бүлэг Үндсэн хөрөнгө; гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "ангилал", "*нийцсэн ба зохистой байх*" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: БҮТЭЗ гэж бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг стандартын дагуу үнэн зөв бүртгэх;

*Илрүүлэлт-2:* Үлдэх өртөггүй, элэгдэл нь дууссан, цаашид дахин үнэлэх, актлах шаардлагатай 10 нэр төрлийн 44 ширхэг 17,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбэж өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн ба зохистой байх*", "тохиолдсон байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх, актлах арга хэмжээг дээд байгууллагын шийдвэрийн дагуу авч хэрэгжүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төсөв, гүйцэтгэл нь төсвийн хэлбэлзлийн тайлангаас зөрүүтэй. | 1 | 15,205.5 | | | 1 | 15,205.5 | 1 | 15,205.5 | | | | |
| Хагас жил болон жилийн эцсийн тооллогоор тооллогын комиссын тоолсон хөрөнгийн тоо ширхэг нь эд хариуцагчийн картаар бүртгэлтэй хөрөнгөөс илүү байна. | 1 | 95,499.3 | 1 | 95,499.3 | | | 1 | 95,499.3 | | | | |
| **Дүн** | **2** | **110,704.8** | **1** | **95,499.3** | **1** | **15,205.5** | **2** | **110,704.8** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмч хамгаалах байнгын зөвлөлийн /өөрийн үндсэн чиг үүргийн ажлаа хийж буй нягтлан бодогч, нярав орсон/ гишүүдийн ажлын байрны чиг үүргийн давхардал болон ажлын үр дүнг үнэлж дүгнэлгүйгээр жилд 2 удаа урамшуулал олгосон. | 1 | 10,018.0 | | | | | 1 | 10,018.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. | 1 | 5,762.5 | | | | | 1 | 5,762.5 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бараа материалыг ангиллын дагуу бүртгээгүй,аж ахуйн материалын дансанд хүнс, бэлэн бүтээгдэхүүн, засварын ажлын материалуудыг бүртгэсэн. | 1 | 6,418.1 | | | | | 1 | 6,418.1 | | | | |
| Үлдэх өртөггүй, элэгдэл нь дууссан, цаашид дахин үнэлэх, актлах шаардлагатай 10 нэр төрлийн 44 ширхэг 17.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **4** | **22,198.6** | | | | | **4** | **22,197.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2024 оны 8 сард орсон Нийслэлийн агентлагуудын шинэ байрны 296 м.кв талбай /дарга, бичиг хэрэг, мэдээллийн технологийн хэлтсийн өрөө болон цайны өрөө/-д засвар хийж, төсвөөс 146.5 сая төгрөгийн засварын зардал гаргасан. | 1 | - | | | | | 1 | - |
| Нийт албан хаагчдын 67 хувьд нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор НЗД-ын захирамж, ТШЗ-ийн тушаалаар нийт 543.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг мөнгөн дүнг ялгавартайгаар, дийлэнхэд хавтгайруулан олгосон. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | 2 | - | | | | | 2 | - |